

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/162/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БАЯНДЭЛГЭР СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Ж.Бямбацогт

Утас: 70272248 Цахим хаяг: byambatsogtj@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн "Релаэнс секьюритиз Аудит" ХХК

Утас: 99813174 Цахим хаяг: rsamongolia@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
 3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
 4. Аудитын тайлан
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт.....
 6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 01/156
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН БАЯНДЭЛГЭР
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ДАРГА Г.УЯНГА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Баяндэлгэр сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Баяндэлгэр сумын эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно. Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 зорилт 4 арга хэмжээтэй боловсруулан төлөвлөж, 90,2 хувиар хэрэгжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Тухайн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл бүхий ажил гүйлгээ байхгүй байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	95,155,590.54	114,428,860.75
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	16,779,619.32	15,246,123.01
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	16,779,619.32	15,246,123.01
3121	Төгрөг	16,779,619.32	15,246,123.01
31211	Төрийн сангийн харилцах	16,779,619.32	15,246,123.01
33	АВЛАГА	15,136.17	8,513,091.98
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	15,136.17	2,639,467.98
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	00.00	5,873,624.00
35	БАРАА МАТЕРИАЛ	78,360,835.05	90,669,645.76
351	Түүхий эд материал	8,856,601.63	23,186,423.08
35130	Эм боох материал	8,856,601.63	23,186,423.08
354	Хангамжийн материал	69,054,233.42	67,033,222.68
35410	Бичиг хэргийн материал	124,500.00	205,500.00
35420	Аж ахуйн материал	34,747,873.07	35,492,573.07
35440	Түлш, шатах тослох материал	4,014,733.17	715,187.97
35460	Хүнсний материал	1,848,826.58	758,387.58
35470	Бусад хангамжийн материал	28,318,300.60	29,861,574.06
35600	Мал амьтад	450,000.00	450,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	264,487,735.02	261,549,743.01
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	264,487,735.02	261,549,743.01
392	Биет хөрөнгө	240,911,735.02	237,973,743.01
39201	Барилга, байгууламж, орон сууц	154,118,053.30	154,118,053.30
39202	Хуримтлагдсан элэгдэл	-29,200,505.00	-32,931,818.12
39203	Авто-тээврийн хэрэгсэл	31,910,000.00	31,910,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-31,910,000.00	-31,910,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	174,567,431.30	187,692,610.30
39206	Хуримтлагдсан элэгдэл	-83,623,638.69	-92,371,932.80
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	35,195,390.08	35,195,390.08
39208	Хуримтлагдсан элэгдэл	-11,526,245.97	-14,922,309.75
39209	Зам, гүүрийн байгууламж	2,225,000.00	2,225,000.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-843,750.00	-1,031,250.00
393	Биет бус хөрөнгө	23,576,000.00	23,576,000.00
39301	Програм хангамж	446,950.00	446,950.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-446,950.00	-446,950.00
39303	Бусад биет бус хөрөнгө	23,576,000.00	23,576,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	359,643,325.56	375,978,603.76
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	867,636.00	1,792,363.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	867,636.00	1,792,363.00
413	Өглөг	867,636.00	1,792,363.00
4136	Бусад өглөг	867,636.00	1,792,363.00
41361	Байгууллагад төлөх өглөг	867,636.00	1,792,363.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	358,775,689.56	374,186,240.76
51	Засгийн газрын хувь оролцоо	358,775,689.56	374,186,240.76
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	95,376,537.48	95,376,537.48
51101	Өмч: - төрийн	95,376,537.48	95,376,537.48
512	Хуримтлагдсан үр дүн	133,087,199.18	148,497,750.38
51210	Өмнөх үеийн үр дүн	133,087,199.18	133,087,199.18
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	15,410,551.20
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	130,311,952.90	130,311,952.90
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	359,643,325.56	375,978,603.76

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	501,250,301.07	431,305,457.07
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	66,291,318.07	33,297,155.73
120	Нийтлэг татварын бус орлого	61,791,318.07	33,297,155.73
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	59,656,318.07	33,297,155.73
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	37,510,859.00	11,840,279.00
120009	Бусад орлого	2,135,000.00	00.00
122	Тусламжийн орлого	4,500,000.00	00.00
122001	Хандив тусламж /дотоод/	4,500,000.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	434,958,983.00	398,008,301.34
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	15,243,365.00	39,636,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	15,243,365.00	39,636,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	71,793,410.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	71,793,410.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	208,500,638.00	00.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	208,500,638.00	00.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	139,421,570.00	358,372,201.34
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	139,421,570.00	358,372,201.34
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	459,776,048.87	415,894,905.87
21	УРСГАЛ ЗАРДАЛ	459,776,048.87	415,894,905.87
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	456,433,968.87	415,600,613.94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	251,168,721.48	258,496,897.43
210101	Үндсэн цалин	157,415,858.03	170,224,526.09
210102	Нэмэгдэл	75,064,306.91	65,782,075.34
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,335,204.54	2,646,000.00
210104	Урамшуулал	10,353,352.00	19,844,296.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,296,804.76	32,345,011.41
210201	Тэтгэврийн даатгал	21,926,052.34	22,308,122.87
210202	Тэтгэмжийн даатгал	2,406,704.90	2,583,244.77
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,925,163.89	2,066,595.86
210204	Ажилгүйдлийн даатгал	458,289.40	489,731.62
210205	Эрүүл мэндийн даатгал	4,580,594.23	4,897,316.29
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,651,920.00	39,341,808.07
210301	Гэрэл, цахилгаан	2,118,921.00	7,884,559.07
210302	Түлш, халаалт	36,532,999.00	31,457,249.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,411,541.06	19,355,539.20
210401	Бичиг хэрэг	1,259,150.00	619,000.00
210402	Тээвэр, шатахуун	12,882,287.86	16,799,545.20
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	900,000.00	1,133,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,370,103.20	780,000.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	23,994.00
2105	Нормативт зардал	59,716,206.96	29,056,162.77
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	53,592,131.96	22,105,923.77
210502	Хоол, хүнс	6,124,075.00	6,650,239.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	300,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	375,000.00	3,400,150.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	3,100,150.00
210604	Урсгал засвар	375,000.00	300,000.00
2107	Томилот, зочны зардал	2,170,000.00	1,415,000.00
210702	Дотоод албан томилот	2,170,000.00	1,415,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,643,000.00	00.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,643,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	54,000,774.61	32,190,045.06
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	24,213,982.40	16,126,874.05
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	29,786,792.21	16,063,171.01
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,342,080.00	294,291.93
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,342,080.00	294,291.93
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,342,080.00	294,291.93
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	41,474,252.20	15,410,551.20
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	41,474,252.20	15,410,551.20

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	492,311,983.00	392,134,677.34
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	492,311,983.00	392,134,677.34
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	72,596,365.00	39,636,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	72,596,365.00	39,636,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	71,793,410.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	71,793,410.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	208,500,638.00	00.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	208,500,638.00	00.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	139,421,570.00	352,498,577.34
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	00.00	00.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	139,421,570.00	352,498,577.34
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	455,957,063.69	392,383,273.65
21	УРСГАЛ ЗАРДАЛ	455,957,063.69	392,383,273.65
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	452,614,983.69	392,088,981.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	251,049,889.11	260,979,798.52
210101	Үндсэн цалин	158,575,702.17	163,685,246.76
210102	Нэмэгдэл	71,037,821.75	75,585,839.60
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,238,204.19	2,590,000.00
210104	Урамшуулал	13,198,161.00	19,118,712.16
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,188,331.51	32,486,442.13
210201	Тэтгэврийн даатгал	21,078,627.97	21,647,779.79
210202	Тэтгэмжийн даатгал	2,539,716.14	2,583,977.44
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,205,965.25	2,069,899.75
210204	Ажилгүйдлийн даатгал	487,847.44	770,604.52
210205	Эрүүл мэндийн даатгал	4,876,174.71	5,414,180.63
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,649,920.00	39,341,808.07
210301	Гэрэл, цахилгаан	2,118,921.00	7,884,559.07
210302	Түлш, халаалт	36,530,999.00	31,457,249.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,390,700.00	16,985,000.00
210401	Бичиг хэрэг	818,850.00	700,000.00
210402	Тээвэр, шатахуун	15,249,900.00	13,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	900,000.00	935,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,421,950.00	1,350,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	500,000.00
2105	Нормативт зардал	64,631,257.07	31,071,783.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	57,631,257.07	23,811,983.00
210502	Хоол, хүнс	7,000,000.00	5,559,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	1,700,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,528,600.00	2,439,850.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,333,000.00	439,700.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	15,695,600.00	1,700,150.00
210604	Урсгал засвар	1,500,000.00	300,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,170,000.00	1,415,000.00
210702	Дотоод албан томилолт	2,170,000.00	1,415,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,006,286.00	7,369,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	24,006,286.00	7,369,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,342,080.00	294,291.93
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,342,080.00	294,291.93
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	36,354,919.32	-248,596.31
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	18,615,300.00	1,284,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	18,615,300.00	1,284,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	18,615,300.00	1,284,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	18,615,300.00	1,284,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-18,615,300.00	-1,284,900.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	17,739,619.32	-1,533,496.31
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	10,261,515.00	16,779,619.32
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	17,739,619.32	15,246,123.01

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	95,376,537.48	130,311,952.90	104,691,817.19	330,380,307.57
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	95,376,537.48	130,311,952.90	104,691,817.19	330,380,307.57
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	41,474,252.20	41,474,252.20
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	95,376,537.48	130,311,952.90	133,087,199.18	358,775,689.56
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	95,376,537.48	130,311,952.90	133,087,199.18	358,775,689.56
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	95,376,537.48	130,311,952.90	133,087,199.18	358,775,689.56
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	15,410,551.20	15,410,551.20
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	95,376,537.48	130,311,952.90	148,497,750.38	374,186,240.76

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	450,597,200.00	354,032,073.65
21	УРСГАЛ ЗАРДАЛ	450,597,200.00	354,032,073.65
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	450,597,200.00	354,032,073.65
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	322,826,700.00	260,979,798.52
210101	Үндсэн цалин	228,253,800.00	163,685,246.76
210102	Нэмэгдэл	63,499,200.00	75,585,839.60
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,175,200.00	2,590,000.00
210104	Урамшуулал	27,898,500.00	19,118,712.16
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,456,600.00	32,486,442.13
210201	Тэтгэврийн даатгал	23,905,800.00	21,647,779.79
210202	Тэтгэмжийн даатгал	2,887,500.00	2,583,977.44
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,310,200.00	2,069,899.75
210204	Ажилгүйдлийн даатгал	577,600.00	770,604.52
210205	Эрүүл мэндийн даатгал	5,775,500.00	5,414,180.63
2104	Хангамж, бараа материалын зардал	24,908,700.00	16,985,000.00
210401	Бичиг хэрэг	1,350,700.00	700,000.00
210402	Тээвэр, шатахуун	18,408,000.00	13,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,150,000.00	935,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,500,000.00	1,350,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,500,000.00	500,000.00
2105	Нормативт зардал	45,498,200.00	31,071,783.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	36,972,000.00	23,811,983.00
210502	Хоол, хүнс	6,426,200.00	5,559,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,100,000.00	1,700,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,667,400.00	3,724,750.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,000,000.00	1,724,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,067,300.00	1,700,150.00
210604	Урсгал засвар	600,100.00	300,000.00
2107	Томиллолт, зочны зардал	2,360,000.00	1,415,000.00
210702	Дотоод албан томиллолт	2,360,000.00	1,415,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11879600.00	7369300.00

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,879,600.00	7,369,300.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	433,974,700.00	352,498,577.34
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	433,974,700.00	352,498,577.34
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	433,974,700.00	352,498,577.34
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	16,779,619.32
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	15,246,123.01
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	19.00	19.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	14.00	14.00
620003	Үйлчлэх ажилтан	04.00	04.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Баяндэлгэр сумын Эрүүл мэндийн төв нь ард иргэдэд Эрүүл мэндийн байгууллагын мэргэжлийн бүх төрлийн чиглэлийн үйл ажиллагаа үзүүлдэг Эрүүл мэндийн яамны харьяа байгууллага юм.

Төв аймгийн Баяндэлгэр сумын эрүүл мэндийн төвийн 2023 оныг "Сувилахуйн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах" жил болгон зарлаж, дэвшүүлсэн зорилго, зорилтын хүрээнд байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 зорилт, 4 арга хэмжээтэйгээр боловсруулан хэрэгжүүлж, төлөвлөгөөг 73,1 хувиар биелүүлж ажилласан байна.

Тус Эрүүл мэндийн төв нь 18 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь үйл ажиллагаандаа

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Эрүүл мэндийн тухай хууль,
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль,
- Төсвийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил гүйлгээ худалдан авах тухай хууль,
- Шилэн дансны тухай хууль,
- Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжууд мөн Сангийн яам болон харьяа эрүүл мэндийн яамнаас гаргасан тушаал, заавар журам шийдвэрүүдийг мөрдөж ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллага 2023 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр Сумын Засаг даргын нэрэмжит шалгалтаар 86,9 хувьтай, Төв аймгийн Эрүүл мэндийн газраас хяналт үнэлгээ шинжилгээний шалгалтаар 86,7 хувьтай тус тус дүгнэсэн байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Баяндэлгэр сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Баяндэлгэр сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 16,335.3 мянган төгрөгөөр буюу 4,5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	16,779.6	15,246.1	-1,533.5
Авлага	15.1	8,513.0	8,497.9
Урьдчилгаа			
Бараа материал	78,360.8	90,669.6	12,308.8
Үндсэн хөрөнгө	264,487.8	261,549.7	2,938.0
Нийт хөрөнгө	359,643.3	375,978.6	16,335.3
Өр төлбөр	867.6	1,792.3	924.7
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	358,775.7	374,186.3	15,410.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	359,643.3	375,978.6	16,335.3

Дээрх хүснэгтээс харахад 2023 оны жилийн эцэст мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 1,533.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Бараа материал дансны үлдэгдэл 12,308.8 мянган төгрөгөөр өссөн нь

- Улсын төсвийн хөрөнгөөр 54,405.6 мянган төгрөгийн эм, эмийн хэрэгсэл боох материал, хүнсний материал, аж ахуйн материал, бичиг хэргийн материал, түлш татах тослох материал, бусад хангамжийн материал худалдан авсан.
- Хандиваар 11,897.3 мянган төгрөгийн эм, эмийн хэрэгсэл боох материал, 9,589.8 мянган төгрөгийн бусад хангамжийн материалыг Аймгийн Эрүүл мэндийн газраас хүлээн авсан.
- Бараа материал данснаас байгууллагын үйл ажиллагаанд 63,553.6 мянган төгрөгийг зарцуулснаас шалтгаалсан байна.

Авлага дансны үлдэгдэл: Эрүүл мэндийн байгууллагаас 5,873.6 мянган төгрөг, ажилчдаас 2,639.4 мянган төгрөг нийт 8,497.9 мянган төгрөгийн авлагатай байна. Энэ нь Эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилтийн үлдэгдэл 5,873.6 мянган төгрөг, 2,639.5 мянган төгрөг нь ажиллагсдад илүү олгосон байна.

Үндсэн хөрөнгө данс нь оны эцэст 261,549.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,938.0 мянган төгрөгөөр буурсан нь элэгдэлтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны дэлгэрэнгүй бүртгэлээс харахад:

- 1,284.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг улсын төсвийн хөрөнгөөр, Эрүүл мэндийн газраас, 11,840.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг хандиваар тус тус авсан ба тайлант онд акталж устгасан үндсэн хөрөнгө байхгүй.

Өр төлбөр дансны үлдэгдэл 1,792,3 мянган төгрөг байна. Өмнөх оноос 924.7 мянган төгрөгөөр өр төлбөр данс нэмэгдсэн бөгөөд энэ нь Тооцоо нийлсэн актаар баталгаажсан дулааны өр байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 376,632.2 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 53,912.5 мянган төгрөг нийт зарлагыг 430,544.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 430,544.7 мянган төгрөгөөр зардлыг баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 430,544.7 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 376,632.2 мянган төгрөгийг, орон нутгийн төсвөөс 53,912.5 мянган төгрөгийг тус тус бүрдүүлсэн ба нийт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр 430,544.7 мянган төгрөг байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 314,395.9 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 39,636.1 мянган төгрөгийн санхүүжилт олгож, нийт 354,032.0 төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн зардлын гүйцэтгэл 354,032.0 мянган төгрөг буюу 82,2 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг нийт 76,512.6 мянган төгрөг, үүнээс

үндсэн цалин 64,568.5 мянган төгрөгөөр, байр ашиглахтай холбоотой зардлыг 14,276.4 мянган төгрөгөөр, хангамжийн бараа материалын зардлыг 5,447.4 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 2,754.4 мянган төгрөгөөр, эд хогшил худалдан авах зардлыг 675.9 мянган төгрөгөөр, бүх төрлийн даатгалын зардлыг 2,669.0 мянган төгрөгөөр, бусад зардлыг 22,119.0 мянган төгрөгөөр тус тус төлөвлөснөөс дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	71602 Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
81603	Үндсэн үйл ажиллагааны зардал	157,366.2	88,514.5	68,551.6	56,2%
83603	Нэмэлт дээд шатны төсвөөс хуваарилсан		2,300.0	2,300.0	
80302	1 иргэнд ноогдох номативт зардал	293,231.0	262,717.4	30,513.5	89,6%
80111	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	53,912.5	39,636.1	14,276.4	73,5%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Баяндэлгэр сумын Эрүүл мэндийн төв нь 2023 онд нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ хийгдээгүй.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/						
№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	71602-81603	2023-12-31	Үндсэн үйл ажиллагааны зардал	56,2%	157,366.2	88,514.5
2	71602-83603	2023-12-31	Нэмэлт дээд шатны төсвөөс хуваарилсан	100%		2,300.0

3	71602-80302	2023-12-31	1 иргэнд ноогдо нормтивт зардал	89,6%	293,231.0	262,717.4
4	71602-80111	2023-12-31	Төрийн өмчит барилгын тогтмол зардал	73,5%	53,912.5	39,636.1

- Үндсэн үйл ажиллагааны арга хэмжээ дутуу хэрэгжсэн нь мэргэжилтэн, боловсон хүчний хангалт дутуу, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн санхүүжилттэй холбоотойгоор дутуу хэрэгжсэн байна. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн
- Нэг иргэнд ноогдох нормативт зардал арга хэмжээ дутуу хэрэгжсэн нь хүн амын насжилт, бүтэцтэй холбоотой.
- Төрийн өмчийн барилгын тогтмол зардал арга хэмжээ дутуу хэрэгжсэн нь урсгал зардал гараагүй, цэвэр усны нэгдсэн системд холбогдоогүй учраас зардал санхүүжилт хийгдээгүй.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн Баяндэлгэр сумын Эрүүл мэндийн төв нь 2023 онд цахим дэлгүүрээс эм, эмнэлгийн хэрэгсэл, боох материалыг 9,617.0 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн байна. Хүнсний бараа материалыг төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагааны зохих журмаар Ургах наран ХХК-с шууд худалдан авалт хийдэг. Мөн шатахуун тослох материалыг НИК ХХК-аас гэрээгээр авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баяндэлгэр сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах анхан шатны бүртгэлийг бүрэн хөтөлж хэвших болон шилэн данстай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Релаэнс секюритиз аудит ХХК-ийн ахлах аудитор Б.Мягмар, аудитор С.Дашдондог нар гүйцэтгэж, хяналтыг Релаэнс секюритиз аудит ХХК-ийн захирал, аудитор Ж.Цэцэгмаа, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Бямбацогт, аудитын менежер О.Амаржаргал, дарга, Тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баяндэлгэр сумын Эрүүл мэндийн төв нь 2023 оны оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Релаэнс секюритиз аудит ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 04 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны санхүүгийн үр

дүнгийн тайлангийн, нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Баяндэлгэр сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 440,000.0 мянган төгрөгөөс 2,0 хувиар буюу 8,800.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 7,040.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хэмнэж ажилласны үр дүнд ажиллагсад олгох цалин хөлстэй холбоотой орон тоог хэмнэж ажиллах, төлөвлөгдсөн бараа ажил үйлчилгээний зардлыг төлөвлөгөөт хэмжээнд нь зарцуулах буюу хэмнэх зэрэг арга хэмжээ авч ажилласан байна.

Төв аймгийн Баяндэлгэр сумын Эрүүл мэндийн төв нь 2023 онд батлагдсан төсвийг үр бүтээлтэй хэрэгжүүлэн ажилласан байна. 2023 оны төсвийг хэмнэж үр бүтээлтэй ажиллах, тогтмол зардал болон эд хогшил худалдан авах зардлыг хэмнэх арга хэмжээ авснаар доорх хэмнэлт гаргасан байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл, урамшууллыг 61,846.9 мянган төгрөгөөр
- Байр ашиглахтай холбоотой болон эд хогшил худалдан авах зардлыг 14,276.4 мянган төгрөгөөр
- Хангамжийн бараа материал болон бусдаар гүйцэтгэх ажил үйлчилгээний зардлыг 7,924.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны хөтлөлтийг шалгахад 2023 онд тус эрүүл мэндийн төв нь 159 мэдээллийг шилэн дансанд байршуулахаас 148 мэдээллийг байршуулж 11 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан. Энэ нь шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.1-д “Мэдээлэл үнэн зөв бодитой иж бүрэн байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд тогтмол шуурхай мэдээлдэг байх”, 6.4.4-д “Таван саяаас дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа ажил гүйлгээ”, Монгол улсын засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 7 дугаар зүйлийн 7.5.3-д “өөрийн хянах цэсийн мэдээллийг байнга хянах” заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансанд хууль, журмын дагуу мэдээллийг цаг тухайд нь оруулж хэвших зөвлөмж өгөв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Баяндэлгэр сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 9 дүгээр сарын 30-наар тасалбар болгосон санхүүгийн тайланд хийгдсэн. Завсрын аудитын явцад хөрөнгийн болон зардлын данстай холбоотой 557.7 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгөгдсөн. Биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад 1 зөвлөмж нь хэрэгжээгүй тул аудитын тайланд тусгаж зөрчлөөр оруулсан болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн бүрэн биелүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		/мянган төгрөгөөр/ Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	3	348.3	3	348.3	100%
Албан шаардлага	1	373,663.0	1	373,663.0	100%
Зөвлөмж	3	22,466.4	3	22,466.4	100%
Нийт дүн	7	396,477.7	7	396,477.7	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны зардлын болон эргэлтийн эмийн сангийн цахим төлбөрийн баримтууд татварын цахим системд нэг регистрээр бүртгэгдэж байгааг үзэх

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 10,413.0 мянган төгрөгийн 3 зөрчил илэрснээс 107.7 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 10,305.3 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн. Үүнд:

5.1 Төлбөрийн акт

- Зардлын данстай холбоотой

Илрүүлэлт:

Хүнсний бүтээгдэхүүний зарцуулалтыг шалгахад батлагдсан жишиг нормыг баримталж ажиллаагүйгээс 107.7 мянган төгрөгийн зөрчил илэрсэн. Энэ нь ЭМЯ-ний сайдын А/74 дүгээр тушаалын 3-р хавсралтаар батлагдсан жишиг нормыг баримталж ажиллах гэсэн заалт, санхүүгийн тайлангийн “Тохиолдсон байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.6-д “Эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Авлага, өглөгийн данстай холбоотой

Илрүүлэлт:

2023 оны санхүүгийн тайлангаар 8,513.0 мянган төгрөгийн авлага үүссэн зөрчил илэрсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах” гэсэн хуулийн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Холбогдох хууль тогтоомжийн дагуу авлагыг хугацаанд нь барагдуулах.

2. Авлага, өглөгийн данстай холбоотой

Илрүүлэлт:

2023 оны санхүүгийн тайлангаар 1,792.3 мянган төгрөгийн өглөг үүссэн зөрчил илэрсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах” гэсэн хуулийн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Холбогдох хууль тогтоомжийн дагуу өглөгийг хугацаанд нь барагдуулах.

Дээрх төлбөрийн акт, зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Хүнсний бүтээгдэхүүний батлагдсан жишиг нормын зарцуулалт хэтэрсэн	1	107.7	1	107.7									
Авлага үүссэн	1	8,513.0					1	8,513.0					
Өглөг үүссэн	1	1,792.3					1	1,792.3					
Дүн	3	10,413.0	1	107.7			2	10,305.3					

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
Шилэн дансанд байршуулах 11 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан	1	53,200.0								1	53,200.0	
Дүн	1	53,200.0								1	53,200.0	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил												
Дүн												
Нийт дүн												

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn